

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6
	1.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	4-5
	2.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	5-6

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Адьяаа, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Л.Мөнхбаатар,
Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн;
Тасалсан: Ш.Раднаасэд, Н.Учрал.

Нэг.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис, мөн штабын Харуул хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнх-Итгэл, ахлах офицер Г.Галдандулжа, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Бат-Амгалан гишүүн ирсэн байна, Бямбацогт гишүүн ирсэн байна, Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Нямбаатар гишүүн ирсэн байна, Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Цогтбаатар гишүүн ирсэн байна, Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, 2.Монгол Улсын Шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД, Чингис Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал, Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Анхбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа, Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Мөнх-Итгэл Дотоодын цэргийн штабын орлогч, Харуул хамгаалалтын хэлтсийн дарга, дэд хурандаа танилцуулж дууслаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Асуулт байна уу? Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Энэ болохоор эцсийн хэлэлцүүлэг учраас нөгөө янз бүрийн тийм санал хэлэх юм алга. Зүгээр нөгөө нэг юу л байна л даа. Тодорхойлолтын нөгөө 3¹ дүгээр зүйлийн дотоодын цэргийн байгууллага гэдгийг тодорхойлохдоо дотоодын цэргийн байгууллага нь төрийн цэргийн байгууллага мөн гээд. Ер нь төрийн цэргийн байгууллага гэдэг нэр томьёо чинь юу билээ? Манай Хууль зүйн яамныхан Цолмон эд нар байна шүү дээ. Энэ чинь ингээд хэрэглэгдээд явдаг билүү. Төрийн цэргийн байгууллага гэж тийм. Тэгэхээр яг ингээд дотоодын цэргийн байгууллага бол төрийн цэргийн байгууллага мөн гээд тийм. Би тэгээд зүгээр яах вэ, энийг нь ингээд тодорхойлчихсон юун дээр нь асуух гэсэн юм.

Ц.Мөнх-Оргил: Сүхбаатар гишүүний асуултад хууль санаачлагч Нямбаатар сайд хариулъя. Нямбаатар гишүүний санал, микрофоныг өгөөрэй.

Х.Нямбаатар: Би асуулт бас яг гүйцэд сонсоогүй. Ер нь бол төрийн цэргийн байгууллагад дотоодын цэргийн байгууллага өөрөө харьяалдаг. 2016 онд санагдаж байна. Төрийн цэргийн байгууллагын багц хуулиуд батлагдахад дотоодын цэргийн байгууллагыг төрийн цэргийн байгууллагын ангилалтад оруулсан. Энэ зохицуулалтыг энэ удаагийн Дотоодын цэргийн тухай хуульд оруулж байгаа. Нэмэлт, өөрчлөлтөөр бататгаж өгч байгаа.

Хоёр гэвэл дотоодын цэргийн байгууллага цагдаагийн байгууллагатай яг адил түвшинд тодорхой нийгмийн баталгаануудыг эдлэх тэр боломж нөхцөлүүдийг энэ хуулиар бас нээж өгч байгаа гэдэг ийм зүйлийг хэлье. Дараа нь би дарга горимын санал гаргаж болох уу?

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа Нямбаатар гишүүн. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол байхгүй байгаа учраас Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан гишүүн танилцуулчих уу? Энх-Амгалан гишүүн танилцуулна. Дараагийн асуудалд орно.